

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2023/241-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Сүхбаатар сум	Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
2023 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Т.Мөнхзул Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:Munkhzult@audit.gov.mn">Munkhzult@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-16
4. Аудитын тайлан	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий Газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2023-09-25 № СЭА-2023/241-НА-СТА-ТШЗ  
Тайлбар \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН  
СУМЫН СУМ ДУНДЫН ЦАГДААГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА Х.АЛТАНХУЯГ  
ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн 1,028,738,9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 100 хувьтай тайлагнагдсан байна.

**Аудитын гол асуудал**

Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн 2022 оны төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 82.1 хувь болох 844,927.9 мянган төгрөгийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд 7.6 хувийг буюу 78,029.5 мянган төгрөгийг байр ашиглалтын тогтмол зардалд зарцуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>69,486,026.61</b>	<b>91,168,570.71</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0</b>	<b>10,533,165.10</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0</b>	<b>10,533,165.10</b>
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	0	10,533,165.10
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3,700,442.00</b>	<b>3,675,542.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>3,700,442.00</b>	<b>3,675,542.00</b>
33520	Хувь хүмүүсээс авах авлага	3,700,442.00	3,675,542.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>65,785,584.61</b>	<b>76,959,863.61</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>39,126,068.61</b>	<b>44,962,821.61</b>
35110	Тусгай зориулалттай материал	38,581,869.61	43,668,821.61
35130	Эм боох материал	544,199.00	1,294,000.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>22,912,765.00</b>	<b>29,090,666.00</b>
35410	Бичиг хэргийн материал	5,912,050.00	9,878,950.00
35420	Аж ахуйн материал	15,651,132.00	14,294,821.00
35440	Түлш, шатах тослох материал	505,587.00	2,826,747.00
35450	Барилгын засварын материал	0	1,342,000.00
35470	Бусад хангамжийн материал	843,996.00	748,148.00
35600	Мал амьтад	3,746,751.00	2,906,376.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>504,480,407.98</b>	<b>470,693,315.13</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>504,480,407.98</b>	<b>470,693,315.13</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>485,066,754.38</b>	<b>451,483,774.93</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	433,406,450.00	433,406,450.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-22,649,377.04	-33,190,547.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	82,244,035.04	76,744,035.04
39204	Хуримтлагдсан элэгдэл	-64,334,142.36	-74,494,035.04
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	91,260,867.43	88,166,447.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-43,557,248.49	-44,760,645.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,232,177.00	21,474,388.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,536,007.20	-15,862,318.60
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>19,413,653.60</b>	<b>19,209,540.20</b>
39301	Програм хангамж	1,020,567.00	1,020,567.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-204,113.40	-408,226.80
39303	Бусад биет бус хөрөнгө	18,597,200.00	18,597,200.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>573,966,434.59</b>	<b>561,861,885.84</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>713,197.00</b>	<b>42,947.20</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>713,197.00</b>	<b>42,947.20</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>713,197.00</b>	<b>42,947.20</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	711,397.00	42,947.20
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>1,800.00</b>	<b>0</b>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,800.00	0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>573,253,237.59</b>	<b>561,818,938.64</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>573,253,237.59</b>	<b>561,818,938.64</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	313,667,225.00	313,667,225.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	313,667,225.00	313,667,225.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>118,493,737.39</b>	<b>107,059,438.44</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	51,751,346.94	118,493,737.39
51220	Тайлант үеийн үр дүн	66,742,390.45	-11,434,298.95

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	141,092,275.20	141,092,275.20
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>573,966,434.59</b>	<b>561,861,885.84</b>


## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,135,771,362.60</b>	<b>1,053,941,614.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>152,525,362.60</b>	<b>23,519,514.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>152,525,362.60</b>	<b>23,519,514.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>133,896,040.00</b>	<b>10,878,653.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,660,300.00	5,582,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	2,637,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	129,235,740.00	2,659,053.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	12,858,436.68	7,873,831.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,770,885.92	4,767,030.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>983,246,000.00</b>	<b>1,030,422,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>981,246,000.00</b>	<b>1,026,738,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	981,246,000.00	1,026,738,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,000,000.00</b>	<b>3,683,200.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	2,300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	1,383,200.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,064,028,972.19</b>	<b>1,065,375,912.95</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,064,028,972.19</b>	<b>1,065,375,912.95</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,060,262,878.06</b>	<b>1,057,082,016.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>816,980,876.00</b>	<b>823,636,868.98</b>
210101	Үндсэн цалин	524,156,805.00	506,387,737.78
210102	Нэмэгдэл	289,474,071.00	281,031,034.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,350,000.00	19,095,000.00
210104	Урамшуулал	0	17,123,097.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,515,689.00</b>	<b>17,949,049.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	1,657,137.00	1,154,526.36
210202	Тэтгэмжийн даатгал	184,495.00	135,828.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	36,900.00	108,662.49
210204	Ажилгүйдлийн даатгал	147,594.00	27,165.62
210205	Эрүүл мэндийн даатгал	16,489,563.00	16,522,866.42

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>65,054,451.47</b>	<b>78,049,436.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	20,592,488.47	16,945,632.80
210302	Түлш, халаалт	40,589,563.00	57,873,289.20
210303	Цэвэр, бохир ус	3,872,400.00	3,230,514.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>65,833,693.74</b>	<b>53,634,421.12</b>
210401	Бичиг хэрэг	8,243,850.00	8,468,400.00
210402	Тээвэр, шатахуун	30,587,032.00	32,905,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,075,132.40	3,787,571.12
210404	Ном, хэвлэл	120,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,991,266.00	4,846,390.00
210408	Бараа материал акалсны зардал	19,696,413.34	3,426,370.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>11,183,468.00</b>	<b>4,771,930.00</b>
210502	Хоол, хүнс	11,183,468.00	4,771,930.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>21,356,562.00</b>	<b>16,047,250.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,148,200.00	2,636,000.00
210604	Урсгал засвар	17,208,362.00	13,411,250.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,941,000.00</b>	<b>6,095,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,941,000.00	6,095,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,522,598.00</b>	<b>2,832,449.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	2,059,301.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,350.00	534,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	143,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	67,248.00	95,848.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>54,874,539.85</b>	<b>54,065,612.85</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	837,475.92	1,991,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,037,063.93	52,073,912.85
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,766,094.13</b>	<b>8,293,896.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,660,000.00</b>	<b>3,377,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,360,000.00	3,377,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,786,445.60</b>	<b>4,916,896.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,786,445.60	4,916,896.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>319,648.53</b>	<b>0</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	319,648.53	0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>71,742,390.41</b>	<b>-11,434,298.95</b>

V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,999,999.96</b>	
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	4,999,999.96	0
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>66,742,390.45</b>	<b>-11,434,298.95</b>




### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>987,906,300.00</b>	<b>1,049,224,161.10</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,660,300.00</b>	<b>18,802,061.10</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,660,300.00</b>	<b>18,802,061.10</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>4,660,300.00</b>	<b>18,802,061.10</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,660,300.00	6,916,896.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	11,885,165.10
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>983,246,000.00</b>	<b>1,030,422,100.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>981,246,000.00</b>	<b>1,026,738,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	981,246,000.00	1,026,738,900.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,000,000.00</b>	<b>3,683,200.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	2,300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	1,383,200.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>987,906,300.00</b>	<b>1,028,278,007.00</b>
299990	Устгал	0	0
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>987,906,300.00</b>	<b>1,028,278,007.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>984,459,854.40</b>	<b>1,016,637,311.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>820,384,820.00</b>	<b>826,902,900.00</b>
210101	Үндсэн цалин	471,252,220.00	472,858,681.66
210102	Нэмэгдэл	349,132,600.00	325,561,942.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	11,739,366.00
210104	Урамшуулал	0	16,742,910.07
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,274,990.00</b>	<b>18,024,600.00</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	18,274,990.00	18,024,600.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>65,114,400.00</b>	<b>78,029,500.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	20,652,437.00	16,945,632.80
210302	Түлш, халаалт	40,589,563.00	57,873,289.20
210303	Цэвэр, бохир ус	3,872,400.00	3,210,578.00

2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,487,132.40</b>	<b>53,245,400.00</b>
210401	Бичиг хэрэг	8,102,000.00	11,524,300.00
210402	Тээвэр, шатахуун	26,770,000.00	31,963,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,075,132.40	3,812,600.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,300,000.00	5,744,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>12,400,000.00</b>	<b>5,543,800.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	742,800.00
210502	Хоол, хүнс	11,100,000.00	4,302,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	498,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,998,362.00</b>	<b>19,804,011.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	3,887,011.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	2,419,500.00
210604	Урсгал засвар	15,998,362.00	13,497,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,765,000.00</b>	<b>6,118,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,765,000.00	6,118,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,455,350.00</b>	<b>6,952,300.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	6,134,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,350.00	534,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	283,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,579,800.00</b>	<b>2,016,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	579,800.00	2,016,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,446,445.60</b>	<b>11,640,696.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,660,000.00</b>	<b>6,723,800.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.00	3,345,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,360,000.00	3,378,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,786,445.60</b>	<b>4,916,896.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,786,445.60	4,916,896.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>0</b>	<b>20,946,154.10</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0</b>	<b>10,412,989.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0</b>	<b>10,412,989.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0</b>	<b>10,412,989.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	10,412,989.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>0</b>	<b>-10,412,989.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0</b>	<b>10,533,165.10</b>

101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	10,533,165.10



#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	313,667,225.00	141,092,275.20	51,751,346.94	506,510,847.14
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	313,667,225.00	141,092,275.20	51,751,346.94	506,510,847.14
9	Тайлант үеийн үр дүн	0	0	66,742,390.45	66,742,390.45
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	313,667,225.00	141,092,275.20	118,493,737.39	573,253,237.59
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	313,667,225.00	141,092,275.20	118,493,737.39	573,253,237.59
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	313,667,225.00	141,092,275.20	118,493,737.39	573,253,237.59
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-11,434,298.95	-11,434,298.95
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	313,667,225.00	141,092,275.20	107,059,438.44	561,818,938.64

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт Хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,028,738,900.00	1,028,738,900.00	0.00	100
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,028,738,900.00	1,028,738,900.00	0.00	100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,023,367,100.00	1,023,367,100.00	0.00	100
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	826,902,900.00	826,902,900.00	0.00	100
210101	Үндсэн цалин	481,746,800.00	472,858,681.66	8,888,118.34	98
210102	Нэмэгдэл	334,156,100.00	325,561,942.27	8,594,157.73	97

210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,000,000.00	11,739,366.00	3,739,366.00	147
210104	Урамшуулал	3,000,000.00	16,742,910.07	13,742,910.07	558
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,024,600.00</b>	<b>18,024,600.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	18,024,600.00	18,024,600.00	0.00	100
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>78,029,500.00</b>	<b>78,029,500.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210301	Гэрэл, цахилгаан	20,170,900.00	16,945,632.80	3,225,267.20	84
210302	Түлш, халаалт	54,852,900.00	57,873,289.20	-3,020,389.20	106
210303	Цэвэр, бохир ус	3,005,700.00	3,210,578.00	-204,878.00	107
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>50,052,200.00</b>	<b>50,052,200.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210401	Бичиг хэрэг	11,534,300.00	11,524,300.00	10,000.00	100
210402	Тээвэр, шатахуун	28,770,400.00	28,770,400.00	0.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,812,600.00	3,812,600.00	0.00	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	190,000.00	200,000.00	-10,000.00	105
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,744,900.00	5,744,900.00	0.00	100
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,293,800.00</b>	<b>5,293,800.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	742,800.00	742,800.00	0.00	100
210502	Хоол, хүнс	4,052,700.00	4,052,700.00	0.00	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	498,300.00	498,300.00	0.00	100
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>30,217,000.00</b>	<b>30,217,000.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,300,000.00	14,300,000.00	0.00	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,419,500.00	2,419,500.00	0.00	100
210604	Урсгал засвар	13,497,500.00	13,497,500.00	0.00	100
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,878,500.00</b>	<b>5,878,500.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210702	Дотоод албан томилолт	5,878,500.00	5,878,500.00	0.00	100
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,952,300.00</b>	<b>6,952,300.00</b>	<b>0.00</b>	<b>100</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,134,700.00	6,134,700.00	0.00	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	534,300.00	534,300.00	0.00	100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	283,300.00	283,300.00	0.00	100

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,016,300.00	2,016,300.00	0.00	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,016,300.00	2,016,300.00	0.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,371,800.00	5,371,800.00	0.00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,371,800.00	5,371,800.00	0.00	100
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,345,300.00	3,345,300.00	0.00	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,026,500.00	2,026,500.00	0.00	100
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,028,738,900.00	1,028,738,900.00	0.00	100
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,026,738,900.00	1,021,822,004.00	4,916,896.00	100
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,026,738,900.00	1,021,822,004.00	4,916,896.00	100
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	6,916,896.00	-4,916,896.00	346
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	6,916,896.00	-4,916,896.00	346

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,683,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,683,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,683,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,193,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,193,200.00
2105	Нормативт зардал	250,000.00
210502	Хоол, хүнс	250,000.00
2107	Томилолт, зочны зардал	240,000.00
210702	Дотоод албан томилолт	240,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,683,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,683,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,383,200.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтэс нь "Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж, шуурхай байдлыг хангах" гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтэс нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх;
- Нийгмийн хэв журам сахиулах;
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах;

Захиргааны хяналт тавих үүрэг гүйцэтгэх буюу хуулиар хүлээлгэсэн хуулийн биелэлтэд хяналт тавих.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна.


Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон
- Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 452 дугаар тогтоолоор Цагдаа, дотоодын цэргийн албан тушаалын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоосон
- ЦЕГ-ын даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/205 дугаар тушаалаар Цалингийн зэрэглэл нэмэгдүүлэх, орон тоо, цолны зэрэглэлд өөрчлөлт оруулсан, 12 дугаар сарын 09-ний өдрийн А/327 дугаар тушаалаар цалингийн зэрэглэлд өөрчлөлт оруулсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд ЦЕГ-ын Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын газраас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтэс нь ЦЕГ-ын даргын 2013 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 422 дугаар тушаалаар Монгол Улсын цагдаа, дотоод цэргийн байгууллагын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,104.6 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	10,533.2	10,533.2
Авлага	3,700.4	3,675.5	-24.9
Бараа материал	65,785.6	76,959.8	11,174.2
Үндсэн хөрөнгө	504,480.4	470,693.3	-33,787.1

<b>Нийт хөрөнгө</b>	<b>573,966.4</b>	<b>561,861.8</b>	<b>-12,104.6</b>
Өр төлбөр	713,1	42,9	670,2
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>573,966.4</b>	<b>561,861.8</b>	<b>-12,104.6</b>
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	573,966.4	561,861.8	-12,104.6

Ахмадын сангийн зарцуулаагүй үлдэгдлээс шалтгаалан мөнгөн хөрөнгө данс 10,533,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Тус газрын нягтлан бодогчоор ажиллаж байсан Ч.Эрдэнэ-Очиртой холбогдолтой авлага хууль, хяналтын байгууллагад шалгагдаж, шийдвэрлэгдэж дуусаагүйгээс шалтгаалан авлага данс 3,675.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Бараа материал данс оны эцэст 76,959.8 мянган төгрөг болж 11,174.2 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 75,661.3 мянган төгрөгийн бараа материал, түлш шатахуун, сэлбэг хэрэгсэл худалдан авсан,
- Систем хоорондын шилжүүлгээр 4,767.0 мянган төгрөгийн бараа материал шилжиж ирсэн,
- Малын нас дэвшилт, төл малын орлогоор 2,571.6 мянган төгрөг хүлээн зөвшөөрсөн,
- Шатахууны урамшуулал болох 1,695.0 мянган төгрөгийг орлогоор бүртгэсэн зэргээр нэмэгдэж,
- Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн даргын 2022 оны 12 дугаар сарын 21 өдрийн А/41 дугаартай тушаалаар 3,426.4 мянган төгрөгийн бараа материал акталж устгасан,
- 70,094.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан зэргээр хорогдсон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 639,409.0 мянган төгрөг болж 11,352.2 мянган төгрөгөөр буурсан нь нь төсвийн санхүүжилтээр 10,412.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 7,873.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг систем хоорондын тооцоогоор үнэ төлбөргүй хүлээн авсан болон Сайхан сумын ИТХ-ын 2022 оны 46 дугаар тогтоолоор 24,139.0 мянган төгрөгийн, аймгийн ОНӨГ-ын 2022 оны 63 дугаар албан бичгээр 29,639.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 561,861.8 мянган төгрөг болж 12,104.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1**

### 3.5.2 Төсвийн төлөвлөлт

Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтэс нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,004,203.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчаас хүргүүлсэн төсвийн төслийн саналаас цалин, хөлс нэмэгдэл, урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 17,773.2 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллыг 49,450.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 2,470.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, хангамжийн бараа материалын зардлыг 12,792.5 мянган төгрөгөөр, норматив зардлыг 1,718.6 мянган төгрөгөөр, хангамж, эд хогшил, урсгал засварын зардлыг 3,326.6 мянган төгрөгөөр тус тус бууруулан 1,019,759.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 8,979.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж /хангамж, бараа материалын зардлыг нэмсэн / зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,028,738.9 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,026,738.0 мянган төгрөгийн санхүүжилт өөрийн орлогоос 2,000.0 авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулж төсвийн гүйцэтгэл 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,020,833.7	1,020,833.7	-	
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	5,371.8	5,371.8		
3	Байцаан шийтгэх ажиллагааны зардал	2,533.4	2,533.4		
	<b>Дүн</b>	<b>1,028,738.9</b>	<b>1,028,738.9</b>		

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130912403 тоот дансанд аймгийн Цагдаагийн газраас хорт ургамлын устгалын зардалд 2,300.0 мянган төгрөг, Амар баясгалан хийдийн хамгаалалтын зардалд 1,383.2 мянган төгрөг зэрэг нийт 3,683.2 мянган төгрөг шилжиж ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 44/3-77 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.


Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,064,028.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,640.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаны даргын 2022 оны 6/947 дугаар "Ажлын чиглэл хүргүүлэх тухай"- дотоод албан бичгийн дагуу тус газар нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэхээс бусад чиглэлээр хөдөө, орон нутагт томилолтоор ажиллахыг зогсоосон,
- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Тээвэр шатахуун, хичээл сургалт үйлдвэрлэлийн зардлыг хэмнэх зорилгоор 1 удаагийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан,

- Ээлжийн амралтаар орон нутагт явах зардлыг олгоогүй байна.



### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, холбогдох баримтад хийсэн завсрын үеийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.


##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага, ер төлбөрийн тооцоог хянан баталгаажуулаагүй, цалингийн тооцооллыг зөв хийж, бүртгэлийг стандартын дагуу гүйцэтгэх, төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх гэх мэт 5 зөвлөмж өгсний дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжих 1 зөвлөмж нь хэрэгжээгүй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	22,605.7	4	22,605.7	80.0
Нийт дүн	5	22,605.7	4	22,605.7	80.0

Дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрийн дагуу хэрэгжээгүй 1 зөвлөмжийг тус дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулахаар шийдвэрлэв.



#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. ЦЕГ-аас “Киа моторс-Монгол” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2021 онд үйлдвэрлэж, орж KIA Sportage суудлын автомашиныг 2021 оны 8 дугаар сард суудлын автомашиныг хүлээн авсан бөгөөд ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албанаас “*Автомашин нийлүүлэх санхүүгийн түрээсийн гэрээ*”-ний дагуу төлбөрийг бүрэн төлж дуусаагүй учир автомашин нь улсын бүртгэлд нийлүүлэгч байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байна.

2. Ажлын үр дүнгээр сахилгын шийтгэл ногдуулж, албан тушаалын үндсэн цалинг тодорхой хувиар бууруулсан 29 албан хаагчийн суутгалыг хийхдээ **үндсэн цалинг бууруулах бус** цалингийн цэсийн нэмэгдэл талд хасах утгаар оруулж тооцсон байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалт болон аймгийн Цагдаагийн газрын холбогдох тушаалуудыг тус тус зөрчсөн байна.

3. Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ЦЕГ-аас 2013 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “*Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль эрхийн актын өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллах шаардлагатай байна.

4. ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 14/1772 дугаар албан бичгийн 8 дугаарт “*Төсвийн зардлын үлдэгдлээр байгууллагынхаа хэрэгцээнд шаардлагатай материалыг худалдан авах болон “Ахмадын сан”-д шилжүүлж, төсвийг бүрэн зарцуулах ажлыг зохион байгуулах*” гэж холбогдох хууль, эрхийн актыг зөрчсөн үүрэг чиглэл өгсний дагуу цалингийн сангийн хэмнэлт 6,855.9 мянган төгрөгийг “Ахмадын сан”-гийн дансанд шилжүүлж, бичиг хэргийн зардлын хэмнэлт болох 5,000.0 мянган төгрөгөөр бичгийн цаас, принтерийн

хор, баримтын хавтас зэрэг хэрэгцээнээс илүү бараа материал худалдан авч нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7 дугаар зүйлийн 7.7 дахь "...Төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд .... төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.6: "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

5. ЦЕГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/336 дугаар тушаалын дагуу нэг удаагийн тэтгэмж, урамшууллын хэмнэгдсэн зардлаас 2,392.0 мянган төгрөг болон Санхүү, аж ахуйн албаны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 14/1772 дугаар албан бичгийн дагуу нийт 7 бүлгийн 13 зардлаас 6,855.9 мянган төгрөг зэрэг тухайн жилийн төсөвт тусгагдаагүй 9,247.0 мянган төгрөгийг "Ахмадын сан"-ийн дансанд шилжүүлж, төсвийн гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байгаа нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 1.3 дахь "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгуулж батлуулсны үндсэн дээр санхүүжүүлэх шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,206.6 мянган төгрөгийн зөрчил илэрч зөвлөмж өглөө.


### 5. Зөвлөмж

#### 5.1. Анхан шатны баримттай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тайлант онд нийт 5,206.6 мянган төгрөгийн бичиг хэргийн, материалын худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг нэр төрөл, тоо хэмжээ тус бүрээр бус бөөн дүнгээр баталгаажуулсан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь " ... Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. ..." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ нэг бүрийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.



## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим баримтыг нэр төрлөөр бус бөөн дүнгээр тусгасан	1	5,206.6					1	5206,6				
<b>Нийт дүн</b>	1	5,206.6					1	5206,6				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								